

Дэлхийн цэрэг улс төрийн байдал улс орнуудын батлан хамгаалах бодлогод үзүүлж буй нөлөөний талаар

Ч.Баттулга

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Батлан хамгаалах судлалын төв*

ABSTRACT

This article examines how the strategic interests and geopolitical rivalries of major powers are influencing global security, particularly the defense policies and activities of countries in the Northeast Asia region. The evolving international environment is compelling nations to reassess, reevaluate, and adapt their national security concepts and defense strategies to address emerging challenges. In the future, ensuring national defense and security will require a comprehensive approach that goes beyond military strength - integrating civic participation, scientific and technological advancement, and regional cooperation as essential components of a resilient and sustainable security framework.

Keywords: *Defense policy, strategy, geopolitics, international relations, Northeast Asia.*

ОРШИЛ

Хүний нийгэм тасралтгүй урагшлан хөгжиж байгаагийн улмаас хөгжлийн үе шат бүхэнд улс орнуудын харилцаа, аюул, заналын шинж чанар, агуулга, түүнээс хамгаалах арга, хэрэгсэл хувьсан өөрчлөгдөж байгаа нь энэ сэдвийг тасралтгүй үргэлжлүүлэн судлахаас аргагүй байдалд хүргэдэг. Ялангуяа шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжлийн өнөө үед улс орныг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаагаа дэлхийн улсууд бараг жил тутам тодотгох болжээ. Бидний амьдарч буй өнөө үед олон улсын харилцаа, хүчний тэнцвэр, геополитикийн өрсөлдөөнд томоохон өөрчлөлтүүд гарч байгаагаараа онцлогтой гэж болно.

АНУ, БНХАУ, ОХУ зэрэг их гүрнүүдийн хоорондын тэмцэл, стратегийн бодлогын өөрчлөлт нь бусад жижиг, дунд улс орнуудын батлан хамгаалах бодлогод шууд болон шууд бусаар нөлөөлж байгаа билээ. Энэхүү өгүүлэлд их гүрнүүдийн харилцаанд буюу дэлхийн улс орнуудын цэрэг, батлан хамгаалахын тэнцвэрт байдалд гарч буй гол өөрчлөлтүүдийг авч үзээд, түүний жижиг, дунд орнуудын батлан хамгаалах бодлогод үзүүлж буй нөлөөллийг шинжлэх болно.

Дэлхийн их гүрнүүдийн харилцаанд гарч буй өөрчлөлт

АНУ–БНХАУ-ын стратегийн өрсөлдөөн худалдаа, технологи, цэргийн

салбарт эрчимжиж, ялангуяа Энэтхэг-Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын орчин хурцдаж байна. Тайванийн хоолой, Өмнөд Хятадын тэнгис нь стратегийн гол халуун цэгүүд болжээ¹.

Хятадын эдийн засгийн хурдтай өсөлт, технологийн дэвшил (5G технологи, хиймэл оюун, сансар, цөмийн хүчин) нь АНУ-ын тэргүүлэх байр сууринд шууд сорилт учруулах болов. АНУ “чөлөөт, нээлттэй Энэтхэг-Номхон далай” (Free and Open Indo-Pacific) стратеги баримталж, бүс нутагт Хятадын нөлөөг хязгаарлахыг зорьж байна. Үүний улмаас Тайванийн хоолой, Өмнөд Хятадын тэнгис зэрэг стратегийн бүсэд хурцадмал байдал нэмэгдэж, цэрэг-стратегийн эвслүүд (QUAD, AUKUS) идэвхжиж, Хятадын эсрэг хариу үйлдлийн шинжтэй болжээ.

Украинд өрнөж буй дайн нь ОХУ-Барууны геополитикийн сөргөлдөөнийг гүнзгийрүүлж, НАТО-гийн гишүүн орнуудын хүрээг тэлж, улам нэгтгэн, олон улсын аюулгүй байдлын асуудалд түүний оролцоог бэхжүүлсэн гэж зарим судлаачид үздэг². Үүнийг Европ дахь аюулгүй байдлын бүтэц дахин өөрчлөгдөж, НАТО илүү нягтарч, гишүүн орнуудын батлан хамгаалах зардал огцом нэмэгдсэнээс харж болно. НАТО өргөжин тэлэх болсон нь түүний болон ОХУ-ын геополитикийн ашиг сонирхлын зөрчлийг улам гүнзгийрүүлж байна. АНУ болон Барууны хориг арга хэмжээ ОХУ-ыг эдийн засгийн болон улс төрийн шахалтад оруулж байгаагаас ОХУ Хятадтай стратегийн түншлэлээ бэхжүүлж, Барууны эсрэг “эвсэл маягийн” харилцааг бий болгож эхэлсэн.

ЗХУ задарснаас хойш дэлхийд үүссэн АНУ-ын ноёрхол бүхий нэг туйлт тогтолцоо өөрчлөгдөж, олон төвтэй, олон туйлт ертөнц бий болох хандлага руу шилжих үйл явц болж байна. Энэ нь Энэтхэг, Турк, Бразил, ӨАБНУ зэрэг дундаж гүрнүүдийн олон улсын тавцан дахь нөлөөг нэмэгдүүлж байгаа талаар судлаачид 2008 оноос бичиж эхэлжээ³. Украины дайны дараа Европын холбоо батлан хамгаалахдаа илүү хөрөнгө оруулж, “стратегийн бие даасан байдал”-д анхаарах боллоо. Одоо БНХАУ, ОХУ, Европын холбоо, Энэтхэг зэрэг тоглогчид олон улсын харилцаанд бие даан нөлөө үзүүлэхийг чармайж байгааг судлаачид дэлхий дахинд олон туйлт тогтолцоо бий болох эхлэл гэж үзэж байна.

Их гүрнүүдийн өрсөлдөөн хурцдахын хэрээр жижиг улсуудад учрах геополитикийн дарамт нэмэгдэж, тэд эвсэл, холбоонд илүү найдлага тавих хандлагатай болж байна. Тухайлбал, Зүүн Европын болон Балтын орнууд аюулгүй байдлаа хангахын тулд НАТО-д түшиглэж байгаа бол Ази-Номхон далайн бүс нутагт АНУ–Япон–Австрали–Энэтхэгийн QUAD хамтын ажиллагаа бэхжиж байна. Геополитикийн сөргөлдөөн их гүрнүүдийг зэвсэглэлээр хөөцөлдөхөд хүргэж байгаа нь улмаар жижиг улсуудад ч нөлөөлж, тэд бас батлан хамгаалах төсвөө нэмэгдүүлэхэд анхаарч эхэллээ. Сүүлийн жилүүдэд Европын орнууд, Зүүн Азийн улсууд зэвсэглэлээ эрчимтэй шинэчилж байна⁴. Улс орнууд уламжлалт батлан

¹ Allison, G. *Destined for War: Can America and China Escape Thucydides's Trap?* Houghton Mifflin Harcourt. 2017.

² Freedman, L. *Ukraine and the Return of Containment*. Foreign Affairs, 2022.

³ Zakaria, F. *The Post-American World*. W. W. Norton & Company, 2008.

⁴ SIPRI Yearbook. Oxford University Press, 2023.

хамгаалах бодлогоо өргөжүүлж, нэмэлтээр кибер хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх (national resilience) бүрдүүлэх асуудлыг стратегийн түвшинд оруулж эхэлсэн. Зарим улсууд их гүрнүүдийн өрсөлдөөний дунд төвийг сахих, эсвэл олон талт харилцаагаа тэнцвэржүүлэх замаар аюулгүй байдлаа хангах стратеги баримталж байна. Үүний нэг жишээ гэвэл Монгол Улсын “гуравдагч хөршийн бодлого”-ыг дурдаж болно.

Их гүрнүүдийн удирдагчдын хийсэн мэдэгдэл, төр, засгаас батлан гаргаж байгаа бодлогын баримт бичгүүд тэдний стратегийн сөргөлдөөний илрэл болж байгааг бид харж байна. АНУ-ын засаг захиргаанаас 2022 онд батлан гаргасан “Энэтхэг-Номхон далайн стратеги (Indo-Pacific Strategy of the United States)” баримт бичигт “Чөлөөт, нээлттэй Энэтхэг-Номхон далай” гэсэн зарчмыг тунхаглаж улс орнууд далайн болон агаарын тээврийн чөлөөтэй зорчих эрх, бусад улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хүндэтгэх олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмуудыг мөрдөх шаардлагатайг онцолсон. АНУ-ын Төрийн Департамент 2024 онд өмнө дурдсан “Энэтхэг-Номхон далайн стратеги” баримт бичгийн хүрээнд “...энэ бүс нутаг аюулгүй, чөлөөтэй, нээлттэй, олон улсын хамтын ажиллагаа, түншлэлд тулгуурлан хөгжих нь ...” АНУ-ын батлан хамгаалах бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн нэг байх болно гэсэн мэдэгдлийг хийсэн.

Украины дайнтай холбоотой хэсэгчилсэн дайчилгааг зарлах үеэр 2022 оны 9 дүгээр сард ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин “...эх орон, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах шаардлагатай...” талаар мэдэгдэл хийснийг олон улсын шинжээчид ОХУ Украинд явуулж байгаа дайны ажиллагаанаас гадна “дотооддоо батлан хамгаалах чадвараа бэхжүүлэх шаардлагатай” гэсэн бодлогын чиглэлийг илэрхийлж байгаа хэмээн тайлбарлаж байна.

Украины нөхцөл байдалтай холбогдуулан 2023 оны хоёрдугаар сард G7-гийн удирдагчдын хийсэн хамтарсан мэдэгдэлд “ОХУ-ын Украины эсрэг явуулж буй дайн тусгаар улсын бүрэн эрхт байдлыг хүндэтгэх олон улсын эрх зүйн тулгуур зарчмыг зөрчсөн хэрэг ...” гэсэн агуулгыг тусгасан байдаг. Энэ бүхнээс үзвэл дэлхийн тэргүүлэх гүрнүүдийн удирдагчид, олон улсын байгууллагуудаас хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хийж байгаа албан ёсны мэдэгдэл, байр сууриа илэрхийлж байгаа байдлаас нэг төвтэй дэлхийн дэг журам үеэ өнгөрөөж олон улсын хүчний тэнцвэрт томоохон өөрчлөлт гарах нь нэгэнт тодорхой болсныг харж болохоор байгаа юм.

Өнөө үед кибер аюулгүй байдал, хиймэл оюун, сансар зэрэг шинэ талбарууд дахь өрсөлдөөн, тэмцэл их гүрнүүдийн харилцааны нэг хэсэг болжээ⁵. Аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлүүд, тэдгээрийг сөрөн зогсох талаар их гүрнүүдийн удирдагчдын мэдэгдэл болон тэдний бодлогын баримт бичгүүдэд далай, тэнгис дэх усан замын аюулгүй, чөлөөтэй байдал, технологийн салбарт давуу байдал олж авах, кибер орчны сорилтуудад илүү анхаарал хандуулах нь чухал болсон гэдгийг онцолж байгаа нь илэрхий байна.

⁵ Horowitz, M. C. *The Promise and Peril of Military Applications of Artificial Intelligence*. Brookings Institution, 2018.

Ихгүрнүүдийн харилцаанд гарч буй өөрчлөлт нь зөвхөнд дэлхийн геополитикийн эрэмбэ, дэг журмыг өөрчлөөд зогсохгүй жижиг, дунд улс орнуудын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, стратегид хүчтэй нөлөөлж байна. Иймээс тэд аюулгүй байдлаа хангахын тулд цэргийн хүч чадлаа үе шаттай нэмэгдүүлэх, олон улсын эвсэл, түншлэлд түшиглэх, шинэ төрлийн аюулд (кибер, мэдээллийн дайн) бэлтгэх, үндэсний дархлаа, сөрөн тэсвэрлэх чадамжаа нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай болжээ. Энэ нь батлан хамгаалах бодлогыг улам олон талт, цогц шинжтэй болгох шинэ чиг хандлага бөгөөд “санхүүжилт, дайчилгааны нөөц, олон улсын хамтын ажиллагаа, технологийн дэвшил”-ийн хүчин зүйлс шинэ бодлогын чухал чиглэл болж байна.

Манай улсын оршин буй бүс нутгийн геостратегийн төлөв байдлыг авч үзэх юм бол Зүүн Ази нь дэлхийн хамгийн их хүн амтай болон ихээхэн аж үйлдвэржсэн, хүчирхэг эдийн засагтай орнууд /монголоос бусад нь/-аас бүрдэж байна. Ази тивд төдийгүй, ер нь дэлхийн хэмжээнд БНХАУ тэргүүлэх үүрэгтэй хүчирхэг гүрэн болж байгаа ба Энэтхэг улсын хүч, нөлөө мөн ихсэх хандлагатай болжээ. Бүс нутгийн орнуудын өрсөлдөөнөөс гадна дэлхийн хүчирхэг гүрнүүдийн бүс нутаг дахь улс төр, эдийн засгийн ашиг сонирхлын зөрчил геостратегийн төлөв байдлыг тодорхойлох бас нэг чухал хүчин зүйл болж байдаг. Ялангуяа Монгол Улсын оршин буй Зүүн Хойд Азид цэрэг, батлан хамгаалах чадавхаараа дэлхийд тэргүүлдэг улс орнууд оршин байдаг онцлогтой бөгөөд эдгээр орнууд ч батлан хамгаалах бодлого стратегиа шинэчлэх ажлыг эрчимтэй хийж байна.

***Бүс нутгийн орнуудын батлан хамгаалах бодлого,
үйл ажиллагааны талаар***

БНХАУ батлан хамгаалах бодлогоо шинэчлэн “Хятадын үндэсний батлан хамгаалах шинэ эринд” нэртэй цагаан номыг 2019 онд батлан гаргасан. Энэ удаагийн цагаан номд АНУ тус улсыг стратегийн өрсөлдөгч хэмээн зарласныг хүлээж аваад зогсохгүй, улам өсөн нэмэгдэж байгаа Хятадын цэргийн хүч АНУ-тай өрсөлдөхөд бэлэн байна гэдгийг зарлан тунхагласнаараа онцлогтой байлаа.

БНХАУ бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлын ирээдүйг тодорхойгүй болгож байгаа хүчнээр АНУ-ыг нэрлэсэн ба үүнийгээ хятадын эсрэг цэргийн эвсэл холбоог бэхжүүлж, бүс нутагт байршуулсан цэргийн хүчээ зузаатган, БНСУ-д Агаарын довтолгооноос хамгаалах (THAAD) систем байршуулсан зэргээр тайлбарлаж байгаа.

БНХАУ-ын удирдлага гол аюул заналаар Тайвань, Түвд, Туркистаны салан тусгаарлах хөдөлгөөн, хөрш орнуудтай үүссэн газар нутгийн маргаан, хятадын үндэсний аюулгүй байдлын эрх ашгийг үл тоомсорлож буй АНУ зэрэг гадны хүчнүүдийг нэрлэж байна. Хятад улс цэргийн хүчээ бэхжүүлэн, шинэчлэл хийж байгаагаа цэвэр өөрийгөө хамгаалах зорилготой бөгөөд энэ нь дэлхийн тэргүүлэх хөгжилтэй улсуудын зэвсэгт хүчнээс ХАЧА хоцорч яваагаас үүдэлтэй гэжээ.

БНХАУ өөрийн энх тайванч бодлогын талаар байнга сурталчилж, Өмнөд болон Зүүн Хятадын тэнгист явуулж байгаа цэргийн үйл ажиллагаагаа энхийн төлөө хүчин чармайлт гэж нотолж байгаа ч бусад улсууд үүнтэй тэр бүр санал

нийлэхгүй байгаа. Ойрын ирээдүйд тус улс цэрэг, эдийн засаг, технологийн талбарт АНУ-ыг гүйцэж түрүүлэн дэлхийд тэргүүлэх их гүрэн болох зорилт тавьсан нь цагаан номд ихээхэн ач холбогдол өгч байгаа цэргийн сургууль дадлагыг байлдааны бодит нөхцөлд ойртуулах, Номхон далайн баруун хэсэг, Өмнөд Хятадын тэнгист Хятадын байлдах чадварыг шинэ түвшинд гаргах тухай заалтуудаас харагддаг. Төрийн бодлогоор дэвшүүлсэн батлан хамгаалах зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд бодит байдалд ойртуулсан байлдааны сургалтуудыг эрчимжүүлж байгаа ба 2012 оноос хойш янз бүрийн стратегийн чиглэлүүд /Өрнө, Дорно, Өмнөд, Хойд ба Төв/-эд явуулах бригад, дивизийн түвшний ай, төрөл цэргүүдийн нэгдсэн сургалтуудыг 80 удаа хийсэн ажээ.

БНХАУ-ын Батлан хамгаалах бодлого, цэргийн стратегид дараах шинэ хандлагууд гарч байна. Үүнд:

- 2022 оноос БНХАУ-ын батлан хамгаалах бодлого хөгжлийн ашиг сонирхлоо хамгаалахад чиглэж, дэлхийн хэмжээнд үүрэг гүйцэтгэхийг онцолсон “Идэвхтэй хамгаалалт”-ын үзэл баримтлалд суурилна.
- ХАЧА-ыг 2049 оны эцэс гэхэд “дэлхийн шилдэг” арми болгон бэхжүүлнэ.
- Ши Жиньпин 2022 оны 10-р сард Намын 20-р их хурлын нээлтийн ёслол дээр хэлсэн үгэндээ, БНХАУ-ын зэвсэгт хүчний цогц хөгжлийг хурдасган ХАЧА-ыг 2027 онд шинэчлэх чухал үе шатыг хэрэгжүүлж, энэ нь Тайванийг нэгтгэх, газар нутгийн маргаан, усан хилийн асуудлыг өөрт тааламжтайгаар эргүүлэх боломжийг олгоно гэжээ.
- 2022 онд ХАЧА “MultiDomain Precision Warfare (MDPW)” нэртэй цэргийн ажиллагааны шинэ үзэл баримтлалыг дэвшүүлсэн. MDPW нь хиймэл оюунд суурилсан C4ISRT⁶ сүлжээг ашиглан АНУ-ын үйл ажиллагааны систем дэх эмзэг байдлыг илрүүлж, өндөр нарийвчлалтай цохилт өгөхийн тулд олон талын хамтарсан хүчийг нэгтгэх зорилготой ажээ.
- ХКН 2022 оны эхээр Цэрэг-иргэний нэгдэл (MCF)⁷ нэртэй стратегийг дэвшүүлсэн. Энэ стратегийн хүрээнд иргэний салбарын шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн бүхий л ололт амжилтыг цэргийн хөгжилд нэгтгэж эдийн засгийн инновацыг ашиглан улс орны батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх зорилготой байна.

БНХАУ 2049 онд болох 100 жилийн ойгоороо “хятад үндэстний агуу сэргэн мандалт”-ийн үеийг эхлүүлэх зорилт тавьж, үүнийг хэрэгжүүлэхийн тулд хүч чадлаа бэхжүүлж, дэлхийн шинэ дэг журмыг тогтоох, тэргүүлэх их гүрэн болох

⁶ *Command, Control, Communications, Computers, Intelligence, Surveillance, Reconnaissance, and Targeting (C4 ISRT)*

⁷ *Military-civil fusion (MCF)*

зорилт тавьж байна. Хятадыг дэлхийд тэргүүлэгч гүрэн болгох энэхүү том амбиц нь түүнийг бүс нутгийн төдийгүй дэлхийн бусад хүчирхэг гүрнүүдтэй багагүй зөрчилд хүргэх нь гарцаагүй тул бүс нутгийн жижиг улсууд энэ үйл явцыг анхааралтай ажиглаж, бодлого, үйл ажиллагаагаа тодотгож байх шаардлага тулгарч байгаа юм.

ОХУ ойрын ирээдүйд дотооддоо олон асуудал шийдвэрлэх шаардлагатай болж байгаагийн зэрэгцээ бүс нутгийн улсууд, Барууны орнуудтай харилцаагаа улам хурцатгаж байгаагаас аюулгүй, тогтвортой байдлын олон сорилттой тулгарах болно. Украины дайн, түүний үр дүн ОХУ-ын гадаад бодлогын чиг хандлагад чухал үүрэг гүйцэтгэх ч улам бүр нарийн төвөгтэй болж буй дэлхийн олон улсын харилцааны өнөөгийн нөхцөл байдалд үүнээс гадна олон хүчин зүйл үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй юм.

ОХУ 2014 онд цэргийнхээ номлолын үндсэн агуулгад зарчмын өөрчлөлт, тодотголыг оруулж өгсөн. “ОХУ-ын цэргийн шинэ номлол”-д өнөө үеийн олон улсын харьцаанд гарч буй хувьсал, өөрчлөлт, түүний хандлага, харилцан хамаарлын асуудлыг үнэлж, дүгнээд цэргийн аюулгүй байдлыг хангахад “Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага”, “Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг”, “Шанхайн хамтын ажиллагааны байгууллага”, “Европын холбоо”, НАТО болон НҮБ, хөрш улсуудтай хоёр талын цэргийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх асуудлыг тусгаж өгсөн байдаг. Хэдий тийм боловч Украины дайнтай холбоотойгоор “Европын холбоо” болон НАТО-тай харилцаа хурцдаж, НҮБ дахь байр суурь нь суларсан, хөрш орнуудтайгаа ч зөрчилдөх болсноос харахад цэргийн номлолд тусгасан зорилтуудыг тэр бүр хэрэгжих албагүй тунхгийн чанартай болгож байна.

“Цэргийн номлол”-д дайны аюулыг цэргийн хүчээр тогтоон барих арга хэмжээний хүрээнд өндөр цэцтэй болон цөмийн зэвсэг ашиглах, төр улс оршиход занал учрах, шууд түрэмгийлэл тохиолдоход хариу цохилт өгөх зорилгоор цөмийн зэвсэг хэрэглэхээ зарлан тунхагласан. Ийм заалт оруулсан нь ОХУ-ын төрийн бодлогын шийдэмгий чанарыг илэрхийлэхийн хамт, төр, нийгмийн байгууллын хүндрэлтэй асуудлууд, Зэвсэгт хүчний эрс шинэчлэлд тохиолдож буй бэрхшээлийг даван туулах гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх сонирхолтой холбоотой болов уу.

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин 2024 онд цөмийн зэвсгийн талаар баримтлах төрийн бодлогын баримт бичгээ шинэчлэн, ОХУ болон түүний холбоотны эсрэг дайн, түрэмгийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор цөмийн зэвсэг хэрэглэж болох тухай заалт оруулсан ба өмнөх номлолд байсан “түрүүлж цөмийн зэвсэг хэрэглэхгүй”, “урьдчилж анхааруулах” зэрэг заалтыг баримт бичгээс хассан. Мөн ОХУ-ын эсрэг баллистик пуужин харвах нь цөмийн зэвсэг хэрэглэх нөхцөл болно гэжээ. ОХУ-ын цөмийн зэвсэг хэрэглэх шинэчилсэн номлолын цөмийн зэвсэггүй орны эсрэг ч цөмийн зэвсэг хэрэглэж болохыг үгүйсгээгүй санаа олон улсыг, түүний дотор ойрын холбоотон болоод байгаа БНХАУ-ыг ч түгшээж байна. ОХУ-ын гадаад харилцаанд цэрэг, зэвсгийн хүчээр далайлгасан түрэмгий бодлого хэт давамгайлж эхэлбэл бусад улсууд төдийгүй холбоотнуудтайгаа ч

зөрчилдөх эрсдэл бас байгаа.

Цэргийн номлолын “улс төр, дипломат, эрх зүй, эдийн засаг, мэдээллийн бүхий л арга хэрэгсэл амжилтгүй болсон тохиолдолд өөрийн үндэсний эрх ашгаа хамгаалах зорилгоор цэргийн арга хэмжээ хэрэгжүүлэх” тухай заалтын босго, шалгуур нэг хүний дарангуйллын засаглалтай улсын хувьд удирдагчийн сэтгэл санааны байдлаас хамааран ямарч байж болох талтай. ОХУ-ын цэргийн номлолын “Гадны цэргийн аюул” бүлгийн эхний заалт “а”-д зааснаар бол Швед, Финлянд, Латви, Литва, Эстони улсууд НАТО-гийн гишүүн болсон нь тус цэргийн эвсэл өргөжиж ОХУ-ын хил тулж ирсэн буюу гадны цэргийн аюул бодитой бий болсны илрэл гэхээр байгаа юм. Үүнээс улбаалан ОХУ үндэсний эрх ашгаа хамгаалахын тулд ямар алхам хийх вэ? гэдгээс хамааран олон улсын аюулгүй байдлын нөхцөл улам ээдрээтэй болж байна.

Япон Улс 2022 онд батлан гаргасан “Үндэсний аюулгүй байдлын стратеги” баримт бичигтээ дэлхийн олон улсын байдлыг томоохон өөрчлөлтийн үед байгааг онцлоод, даяаршил, улс орнуудын харилцан хамааралтай байдал нь даян дэлхийн энх тайван, хөгжлийн баталгаа болж чадахгүй байна гэж дүгнэжээ. Дэлхий даяар хүчний тэнцвэр өөрчлөгдөх үйл явц болж байгаагийн зэрэгцээ Энэтхэг-Номхон далайн бүс, тухайлбал Японы эргэн тойронд цэргийн хүчнүүд идэвхжиж, түүний дотор, пуужин - цөмийн зэвсгээр хөөцөлдөх явдал эрчимжиж байна. Аюулгүй байдлын өнөөгийн нөхцөлөөс үүдэн Япон улс батлан хамгаалах чадавхынхаа үндсийг яаралтай бэхжүүлэх зорилт тавьсан. Энэ стратегийн хүрээнд 2027 он гэхэд Япон улс гадны түрэмгийллээс хамгаалах чадавхаа сайжруулан, холбоотон улсуудтай харилцаагаа бэхжүүлэх, цаашид 10 жилийн хугацаанд Япон улсын эсрэг аливаа түрэмгийллийг эрт урьдчилан таслан зогсоох цэргийн чадавхыг бий болгоно гэжээ.

Япон Улсын Батлан хамгаалах яамнаас 2024 онд гаргасан “Батлан хамгаалах цагаан ном”-д дэлхийн олон улсын байдлыг дэлхийн II дайнаас хойш үүссэн хамгийн төвөгтэй нөхцөл гэж үнэлээд өөрийгөө батлан хамгаалах гурван гол зорилтыг тодорхойлсон. Үүний нэгд, Агаарын болон пуужингийн довтолгооноос хамгаалах нэгдсэн чадавхыг бүрдүүлэх; *хоёрт*, холбоотон, түнш орнуудтайгаа хамтын ажиллагаагаа бэхжүүлж, хамтарсан сургалт, дадлагуудаа эрчимжүүлэх, шинэ үеийн сөнөөгч нисэх онгоц бүтээх талаар хамтран ажиллах; *гуравт*, японы Зэвсэгт /өөрийгөө хамгаалах/ хүчний хүний нөөцийн хангалт, бэлтгэлжилтийг сайжруулж, цэргийн албыг хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц хангамжтай ажлын байр болгох зэрэг нь ирээдүйн Японы батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх суурь нөхцөл гэж үзэж байна.

Япон Улсад заналхийлж буй аюул, заналаар Тайванийн эргэн тойрон дахь Хятадын цэргийн идэвхжил, Өмнөд Хятадын тэнгист дэх үйл ажиллагаа, Японы орчимд хийж байгаа Хятад - ОХУ-ын цэргийн хамтарсан сургууль, Хойд Солонгосын цөмийн зэвсэг, пуужингийн туршилтууд зэргийг нэрлэжээ. Үүсэн бий болсон олон улсын цэрэг стратегийн нөхцөлөөс үүдэн тус улс “Батлан хамгаалахыг

бэхжүүлэх хөтөлбөр”⁸-ийг хэрэгжүүлж эхэлсэн ба энэ хөтөлбөрийг 2023-2027 онд нийт 43 их наяд иенээр санхүүжүүлэхээр шийдвэрлэжээ.

Япон Улсын батлан хамгаалах бодлого 1947 оны Үндсэн хуулийн 9-р зүйлд заасан «дайнаас татгалзах» зарчимд үндэслэн энх тайвныг эрхэмлэсэн, зөвхөн өөрийгөө хамгаалалтын чиг баримжаатай байсан бол 2010-аад оноос эхлэн бүс нутгийн аюулгүй байдлын орчин өөрчлөлтөөс үүдэлтэйгээр батлан хамгаалах бодлогоо аажмаар шинэчилж, уламжлалт өөрийгөө хамгаалах чиг баримжаанаасаа хальж, бүс нутгийн аюулгүй байдлын шинэ сорилтуудад хариу үйлдэл үзүүлэх чадварыг хөгжүүлэх болсон. Өөрөөр хэлбэл урьд нь зөвхөн өөрийн нутаг дэвсгэрээр хязгаарлаж байсан батлан хамгаалах үйл ажиллагааны хүрээг ихээхэн өргөжүүлж, бүс нутгийн хэмжээнд үүрэг гүйцэтгэх, аюул эрсдэл үүсвэл аливаа халдлага түрэмгийллээс сэргийлэхийн тулд заналхийлсэн улсын нутгийн гүнд цохилт өгч халдлагыг урьдчилан таслан зогсоох чадавхтай болох зорилтыг үе шаттай хэрэгжүүлж байна. Япон улсын батлан хамгаалах зардал 2023 онд ДНБ-ний 1,2% байсан⁹ бол 2024 онд 8,9 их наяд иен буюу 1.6% болгон нэмэгдүүлж, 2027 он гэхэд 2% хүргэх зорилт тавьсан. Дэлхийн II дайнаас хойш баримталж ирсэн Япон улсын батлан хамгаалах бодлогод 2000 он гарсаар ихээхэн өөрчлөлт орж, цэргийн зардал, зэвсэглэл техникийн хүчин чадал, бие бүрэлдэхүүнийг чадваржуулах чиглэлд ихээхэн анхаарал хандуулах болсон нь тус улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлогын баримт бичгүүдээс харагдаж байна.

БНСУ тус улсын төрөөс батлан хамгаалах талаар баримтлах бодлогын баримт бичиг “Батлан хамгаалахын цагаан ном 2022”-ыг 2023 оны 7 дугаар сард батлан гаргасан. Энэхүү баримт бичигт олон улсын аюулгүй байдлын гол асуудлаар АНУ, БНХАУ-ын хооронд болж буй стратегийн өрсөлдөөнийг онцолсон байна. Түүнчлэн Дэлхийн II дайны дараа тогтсон олон улсын харилцааны дэг журам, норм, хэм хэмжээ алдагдах болж Украины дайнаас үүдэлтэй Европын орнууд цэрэг, зэвсгийн хүчээ нэмэгдүүлж эхэлсэн, Ойрхи Дорнодод Израйл-Палестин, Йемен, Сири, Ази тивд Афганистан, Мьянмар, Энэтхэгийн Кашмир муж, Солонгосын хойг, Өмнөд Хятадын тэнгис зэрэг газруудад хурцадмал байдлууд үүсэж байгаа зэрэг нь дэлхийн болон бүс нутгийн энх тайван тогтвортой байдлын ирээдүйг ихээхэн бүрхэг болгож байгаа гэж дүгнэжээ.

БНСУ-ын Батлан хамгаалах бодлогын үндсэн чиглэл нь Хойд Солонгосын аюулаас хамгаалахад оршиж байгаа бөгөөд энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Зэвсэгт хүчний байнгын бэлэн байдлыг хангах,
- Гурван тэнхлэгийн Батлан хамгаалах чадавх (3K Defense Capabilities)¹⁰-ийг бүрдүүлэх,
- Олон талт аюулыг сөрөн зогсох боломжийг нэмэгдүүлэх,

⁸ Defense Buildup Program of Japan 2022.

⁹ <https://data.worldbank.org/indicator/MS.MIL.XPND.GD.ZS>

¹⁰ “Гурван тэнхлэгийн Батлан хамгаалах чадавх” нь 1. Хойд Солонгосын цөмийн болон пуужингийн зэвсгийг устгах, 2. Агаарын дайралт, пуужингийн довтолгооноос хамгаалах, 3. Хариу цохилт өгөх гэсэн гурван цогцолбор системээс бүрдэнэ

- Төр-иргэн-цэрэг-цагдаа-гамшгаас хамгаалахын нэгдсэн батлан хамгаалах тогтолцоог бий болгох,
- ЗХ-ний гүйцэтгэх байлдааны үүрэг, цэргийн хүчний байлдах зориг эрмэлзлийг дэмжсэн сургалт, бэлтгэлийг явуулах,
- Цэргийн хүчээр Солонгосын хойгт энх тайвныг баталгаажуулах зэрэг болно.

БНСУ-ын төсвийн орлого буурч байгаа хэдий ч батлан хамгаалах зардал 2022 онд 3,4%-аар өссөн бол 2023 онд 4,4%-аар нэмэгдүүлэн нийт 57 их наяд воны хэмжээнд хүргэжээ. Түүгээр ч зогсохгүй тус улсын “Батлан хамгаалахын дунд хугацааны /2023-2027 он/ хөтөлбөр”-т цаашид батлан хамгаалах зардлыг жил тутам 6,8%-аар нэмэгдүүлэн шинэ зэвсэг техникийн худалдан авалт, нийлүүлэлтэд энэ 4 жилийн хугацаанд нийт 107,4 их наяд вон, үүнээс зэвсэглэл техникийн ашиглалт, үйлчилгээний зардалд 99,8 их наядыг зарцуулахаар төлөвлөж байна.

Дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эхний ээлжид цөмийн зэвсэг болон пуужингийн довтолгооноос хамгаалах чадавх сайжирна. Хоёрдугаарт, газар, агаар, сансар, кибер, цахилгаан соронзон зэрэг байлдааны ажиллагааны бүхий л орон зайд цэргийн ажиллагааг явуулах чадварыг бий болгоно. Гуравдугаарт, хиймэл оюунд суурилсан зэвсэглэлийн технологийн хөгжилд хөрөнгө оруулснаар цэргийн хүчний үүрэг гүйцэтгэх чадварыг шинэ шатанд гаргахаар төлөвлөж байна.

БНАСАУ 2020 оны 1 дүгээр сард “Фронтын цөмрөлт”¹¹ нэртэй стратегийн шинэ чиг шугам /бодлого/-ыг зарлав. 2021 онд болсон Хөдөлмөрийн намын VIII их хурлын үеэр Хойд Солонгосын удирдлага батлан хамгаалах стратегийн хэд хэдэн шинэ зорилтуудыг танилцуулсан. 2022 оны есдүгээр сард Ардын их хурлын үеэр БНАСАУ цөмийн хүчин чадлаа хөгжүүлэх бодлогоо орхихгүй гэдгээ нотолж “Цөмийн зэвсгийн бодлогын тухай хууль”-ийг баталсан. БНАСАУ цөмийн болон пуужингийн хүчин чадавхаа хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж, ЗХ-нийхээ үүрэг гүйцэтгэх чадварыг сайжруулах замаар олон улсын тавцанд байр сууриа бэхжүүлэхийг эрмэлзэж байгаа. Тус улс Украйны фронтод цэргийн алба хаагчдаа илгээж байлдааны туршлага суулгаж байгаа гэсэн байр суурийг зарим хэвлэлд бичиж байна.

Хойд Солонгосын цэргийн бодлого 1962 оноос мөрдөж байгаа “өөрийн хүчээр хамгаалах” зарчмын хүрээнд цэргийн хүчийг хөгжүүлэх Солонгосын Ардын Арми /САА/-ийг “Улс төр, үзэл суртлын хувьд илүү хүчирхэг болгох”, “Ёс суртахууны хувьд илүү хүчирхэг болгох”, “Шилдэг тактиктэй арми болгох”, “Төрөл мэргэжлийн цэргийг бэхжүүлэх” гэсэн дөрвөн жанжин шугамыг баримталсан хэвээр байгаа юм. Өнөөгийн байдлаар тус улсын “Кибер ажиллагааны хүчин”-д 6800 хүн алба хааж, шинэ технологи хөгжүүлэх, ЗХ-д кибер дэмжлэг үзүүлэхээр ажилладаг тухай мэдээлэл байна.

БНАСАУ-ын батлан хамгаалах бодлогыг тоймлон авч үзвэл түүний үндэс нь “цөмийн зэвсгээр далайлган сүрдүүлэх”¹² дээр суурилж байгаа ба улс орны

¹¹ *Frontal Breakthrough. Hanbyeol Sohn, Taehyun Kim. Deciphering North Korea's Military Activities. 2024.*

¹² *Defense White Paper 2022. Ministry of National Defense, Republic of Korea 2023.*

хэмжээнд хэт цэрэгжсэн бодлогоо АНУ-ын аюул, заналаас хамгаалах гэсэн зорилгоор тайлбарлаж, дайн, байлдаан явуулахдаа тулбал “хүч тэнцвэргүй / ассиметрик/ дайны” арга тактик хэрэглэх, үүндээ цөмийн болон үй олноор хөнөөх зэвсэг ашигласан “гэнэтийн цохилт”-д ихээхэн найдлага тавьж байна.

ДҮГНЭЛТ

Дэлхийн тэргүүлэх хөгжилтэй орнуудын хэмжээнд батлан хамгаалах, цэрэг, зэвсгийн хүч чадлаа нэмэгдүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна. Дийлэнх улсууд батлан хамгаалах зардлаа нэмэгдүүлж байгаа ба цэргийн хүчийг бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд алсын зайн цохилтын хэрэгслүүд нисэх онгоц, пуужин, нисгэгчгүй нисэх хэрэгсэл /ННХ/, дрон зэрэг зэвсэглэлийн тоо, хэмжээг нэмэгдүүлэх хэт өндөр хурдтай баллистик пуужин, хиймэл оюунд суурилсан алсын удирдлагатай болон байлдааны тодорхой үүргийг бие даан гүйцэтгэх чадвартай робот зэвсэглэлийн тэргүүний технологийг хөгжүүлэх, эзэмшихэд онцгой анхаарах боллоо.

Ерөнхийдөө дэлхийн улсуудын батлан хамгаалах бодлого үйл ажиллагаанд гарч буй дараах шинэ хандлагуудыг тэмдэглэж болно. Үүнд:

- Аюулгүй байдлын орчны олон талт шинж нэмэгдэж, уламжлалт цэрэг, зэвсгийн аюулаас гадна кибер халдлага, мэдээллийн дайн, уур амьсгалын өөрчлөлт зэрэг шинэ сорилтуудыг батлан хамгаалах бодлогод тусгах болж, түүний хамрах хүрээг тэлж байна.
- Цэрэг-технологийн шинэчлэл эрчимжиж, хиймэл оюун, дроны технологи, сансар дахь цэрэг-стратегийн өрсөлдөөн зэрэг нь батлан хамгаалахын тэргүүлэх чиглэлд орж, орчин үеийн зэвсэглэлд технологийн дэвшил чухал үүрэгтэй болов.
- Хамтын аюулгүй байдал, эвсэлд түшиглэсэн бодлогод ихээхэн ач холбогдол өгөх болж бүс нутгийн болон глобал эвслүүдийн үүрэг нэмэгдэж, улс орнууд ганцаар бус эвсэл, түншлэлд суурилсан хамгаалалтыг илүүд үзэж боллоо.
- Иргэн-төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд анхаарал хандуулж, бүх нийтийн оролцоог хангасан Батлан хамгаалах тогтолцоо гэсэн ойлголт гарч ирж байна.

Зүүн Хойд Азийн орнуудын батлан хамгаалах бодлогын хандлагуудыг дараах байдлаар тоймлож болохоор байна. Үүнд:

1. Бүс нутагт АНУ-БНХАУ-ын стратегийн өрсөлдөөн, БНАСАУ-ын цөмийн хөтөлбөр, Тайванийн асуудал зэрэг нь батлан хамгаалах бодлого, зэвсэглэлд шууд нөлөөлж, улсууд өөрсдийн цэргийн чадавхыг эрчимтэй нэмэгдүүлж байна.
2. БНАСАУ цөмийн болон пуужингийн туршилтаа үргэлжлүүлж, АНУ болон бүс нутгийн орнууд хариу арга хэмжээ авч буй нь бүс нутгийн цэргийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлж байна.
3. Бүс нутгийн орнуудын батлан хамгаалах зардал нэмэгдэж, шинэ технологит

суурилсан зэвсэглэл, техникийн хүчин чадал дараах байдлаар нэмэгдэж байна. Үүнд:

- Япон улс батлан хамгаалах төсвөө огцом нэмэгдүүлж, довтолгоо, цохилтын чадавх бүхий зэвсэг (нисэх онгоц, пуужин, дрон зэрэг)-т анхаарах болсон,
 - БНСУ кибер аюулгүй байдал, пуужингийн хамгаалалтаа сайжруулж байна,
 - БНХАУ Зэвсэгт хүчнээ шинэчилж, бүс нутагт тэргүүлээ бэхжүүлэх зорилготойгоор Тэнгисийн болон Агаарын хүчинд ихээхэн хөрөнгө оруулалт хийж байна.
4. Эвсэл холбоо ба стратегийн түншлэл нэмэгдэж, Япон болон БНСУ АНУ-тай стратегийн холбоогоо бэхжүүлж, БНХАУ, ОХУ цэргийн хамтарсан дадлага сургууль хийж, АНУ-ын бүс нутаг дахь нөлөөг сөргүүлэн хамтын ажиллагаагаа өргөтгөж байна.
5. Цэргийн стратеги, хууль эрх зүйн хүрээнд шинэчлэл өөрчлөлт гарч байна. Япон улс уламжлалт “өөрийгөө хамгаалах” бодлогоосоо халин, идэвхтэй хамгаалалтын стратеги баталсан бол БНСУ технологийн дэвшилд тулгуурласан батлан хамгаалах шинэ стратеги боловсруулж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Allison, G. Destined for War: Can America and China Escape Thucydides's Trap? Houghton Mifflin Harcourt. 2017.
2. Freedman, L. Ukraine and the Return of Containment. Foreign Affairs, 2022.
3. Horowitz, M. C. The Promise and Peril of Military Applications of Artificial Intelligence. Brookings Institution, 2018.
4. SIPRI Yearbook “Military Expenditure Database”. Oxford University Press, 2023.
5. Zakaria, F. The Post-American World. W. W. Norton & Company, 2008.
6. Военная доктрина Российской Федерации 2014.
7. Defense White Paper China 2019.
8. Military and security developments involving the PRC. US DOD, Annual Report to Congress, 2023.
9. National Security Strategy of Japan 2022.
10. National Defense Strategy of Japan 2022.
11. Defense Buildup Program of Japan 2022.
12. Development of Seamless Security Legislation to Ensure Japan's Survival and Protect its People, 2014.
13. Defense White Paper 2022. Ministry of National Defense, ROK, 2023.
14. <https://www.cfr.org/blog/south-koreas-revitalized-three-axis-system>
15. <https://data.worldbank.org/indicator/MS.MIL.XPND.GD.ZS>
16. <https://edition.cnn.com/2025/03/27/europe/north-korea-russia-ukraine-soldiers-intl-hnk>
17. Hanbyeol Sohn, Taehyun Kim. Deciphering North Korea's Military Activities. Korea National Defense University (KNDU), 2024.
18. Homer T. Hodge. North Korea's Military Strategy. US Army War College, 2003.
19. Global Strategic Trends Out to 2055. UK Ministry of Defence, 2024.